

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ I ДҮГЭЭР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 04 дүгээр сарын 09

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2025 оны I улирлын дүнгээр гүйцэтгэсэн ажлын товч тайланг танилцуулж байна.

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгын талаар:

Төрийн албаны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2-т заасныг хэрэгжүүлж, байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсаар төрийн тусгай гүйцэтгэх 7 албан тушаалын сул орон тоог 02 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсаар төрийн жинхэнэ албан хаагчдын дунд зарлаж, 1 орон тоог төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулахаар нөхсөн.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас баримт бичиг хүлээн авах shalgalt@immigration.gov.mn цахим хаягаар Захиргаа, удирдлагын газарт хуулийн мэргэжилтний албан тушаалд хүсэлт ирүүлсэн 1 төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Бусад 6 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нээлттэй зарлуулахаар Төрийн албаны зөвлөлд салбар зөвлөлийн 02 дугаар сарын 25-ны өдрийн 01 албан бичгээр захиалгыг хүргүүлсэн бөгөөд Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсаар 04 дүгээр сарын 04-18-ны өдрүүдэд нээлттэй зарлаж, тусгай шалгалтыг 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулахаар хүлээгдэж байна.

№	Албан бичгийн огноо, дугаар	Сул орон тоо		Албан тушаалын нэр
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2025.02.27 №01	-	6	Санхүү, хангалт үйлчилгээний газрын үндсэн хөрөнгө, бараа материал хариуцсан мэргэжилтэн-1; Хойд бүс дэх газрын мэдээллийн технологийн мэргэжилтэн-1; Хойд бүс дэх газрын хяналтын улсын байцаагч-2; Зүүн бүс дэх газрын хяналтын улсын байцаагч-2.
ДҮН		-	6	

Хоёр. Бусад үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем”-ийг хөгжүүлж, 4271 байгууллагыг хамарсан, нийт 228820 албан хаагчийн мэдээлэл бүхий их өгөгдлийн суурийг бий болгосон бөгөөд энэ оны 01 дүгээр сарын 31-ний өдөр болсон цахим

системийн танилцуулах уулзалтад оролцож, шинээр хөгжүүлсэн зарим модуль, дэд системүүдийн шинэчлэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

- Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд шинэчлэлт хийгдсэнтэй холбогдуулан төрийн албан хаагч бүр системд байгаа өөрийн мэдээлэлтэй танилцах, засварлах хүсэлт илгээх боломжтой болсонтой холбогдуулан нийт албан хаагчид www.csc.gov.mn цахим хуудасны “Төрийн албан хаагчийн портал” цэсэд танилт нэвтрэлтийн ДАН системээр нэвтрэн орж, өөрийн мэдээлэлтэй танилцах, засварлах шаардлагатай мэдээллийн хүсэлтийг илгээх, засварлуулах, баталгаажуулах тухай Захиргаа, удирдлагын газрын даргын 03 дугаар сарын 07-ны өдрийн 02/29 дотоод албан бичгээр төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд чиглэл хүргүүлсэн.
- Байгууллагын бүтэц, орон тооны мэдээлэл, төрийн тусгай удирдах, гүйцэтгэх албан тушаалын 252 албан тушаалд хамаарах 76 албан тушаалын тодорхойлолт, төрийн үйлчилгээний мэргэжлийн болон туслах 64 албан тушаалд хамаарах 20 ажлын байрны тодорхойлолтыг “Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд хүний нөөцийн мэргэжилтнүүдийн оруулсныг салбар зөвлөлөөс нэг бүрчлэн хянаж, баталгаажуулсан.

Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем”-ийг хөгжүүлэлт хийгдсэнээр дараах шинэчлэл хийгдэх юм.

- Төрийн албаны тоо бүртгэл, статистик тоон мэдээллийг иргэн, судлаач, байгууллага үзэх, үйл ажиллагаандаа ашигладаг байхаар тасралтгүй ажиллах dashboard (тайлангийн хуудас)-ийг хөгжүүллээ. Ингэснээр хуулиар хориглоогүй, нээлттэй тоон мэдээллийг хүсэлт гаргаж, цаасаар авах шаардлагагүй болж, хялбарчлагдлаа.
- Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн модулиудыг хөгжүүлж нэвтрүүлсний үр дүнд төрийн албаны их өгөгдлийг бий болгох, судалгаа шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах тогтолцооны суурь тавигдаж, шаардлагатай мэдээллийг богино хугацаанд гаргах, дүн шинжилгээ хийж боловсруулах боломж бүрдэж байна.
- Төрийн албан хаагчийн оролцооны модулын хүрээнд төрийн албан хаагч нэгдсэн систем дэх хувийн хэргийн мэдээлэлтэйгээ танилцах, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих, засвар хийлгэх боломжтой болж, хүний нөөцийн мэргэжилтний баталгаажуулсан анкетыг дахин гараар бичих шаардлагагүй болж, QR кодоор баталгаажуулсан анкетаа илгээх, хэвлэх боломж бүрдсэн. Түүнчлэн төрийн албан хаагч мэргэжил, шаардлага, ур чадвартаа тохирох сул орон тооны мэдээллийг системээр дамжуулан үзэх, тэдгээр орон тооноос сонголт хийх, шалгалтад орох, карьераа төлөвлөх боломжтой болсон.
- Төрийн байгууллагуудын нэгдсэн бүртгэл, хяналтын систем модулын хүрээнд төрийн албанд гарч байгаа хууль бус томилгоог төлөвлөгөөт шалгалт болон өргөдөл, мэдээллийн дагуу хянадаг байсныг зөрчилтэй томилгооны мэдэгдэл цахим системд ирж, иж бүрэн хянах боломжийг бүрдүүлснээр хууль бус

томилгооны улмаас төрд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломжтой болох юм байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 02 дугаар тушаалаар яам, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлтэй хамтран Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах зорилгоор 21 аймгийн 330 сумдад ажиллахаар шийдвэрлэсний дагуу байгууллагаас 2 албан хаагчийг 2, 3 дугаар сард ээлжийн хуваариар албан томилолтоор ажиллуулсан.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийг төлөөлөн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн 02 дугаар сарын 06-18-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Галшар, Баянхутаг, Хэрлэн, Мөрөн, Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн, Булган, Сэргэлэн сумдад, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн 03 дугаар сарын 17-31-ний өдрүүдэд Ховд аймгийн Дарви, Мөст, Цэцэг, Говь-Алтай аймгийн Тонхил, Дарви, Төгрөг, Бугат, Шарга, Баян-Уул сумдад албан томилолтоор ажилласан.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ